

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



---

**ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН БОЛОН ДАХИН  
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЭРХИЙН АКТЫН  
ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.**

**АУДИТЫН КОД: СЭА-2022/20-12-НА-СТА**

**ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ,  
ГҮЙЦЭТГЭЛ**

---

Сүхбаатар сум 2022 он



**Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа**

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

**Аудитын менежер Б.Батмөнх**

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

**Аудитор Д.Чулуунцэцэг**

Утас: 70362442 Цахим хаяг: [chuluuntsetsegd@audit.gov.mn](mailto:chuluuntsetsegd@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

**Үндсэн мэдээлэл**

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ,  
ХУВААРИЛСАН УУ?**

- 1.1 Аймгийн Сонгуулийн хороо, УБХ-ийн зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан уу?
- 1.2 Сумдын Сонгуулийн хороодын зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан уу?

**БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?**

- 2.1 Аймаг, сумын Сонгуулийн хороод төсөв, санхүүжилтийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?
- 2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу?
- 2.3 Хөрөнгийн зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт хийсэн үү?

**Илэрсэн зөрчил**

**Аудитын дүгнэлт**

**Аудитын зөвлөмж**

**Тайлангийн төсөлд ирүүлсэн санал, шийдвэрлэлт**

## Товчилсон үгийн тайлбар

<b>АДБОУС</b>		Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
<b>МТБ</b>		Мэдээлэл технологийн баг
<b>САС</b>		Сонгуулийн автоматжуулсан систем
<b>СЭА</b>		Сэлэнгэ аймаг
<b>СЕХ</b>		Сонгуулийн ерөнхий хороо
<b>УБХ</b>		Улсын бүртгэлийн хэлтэс
<b>УИХ</b>		Улсын Их Хурал
<b>ИТХ</b>		Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ:**

### **Аудитын нэр**

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл

### **Аудитын код:**

СЭА-2022/20-12-НА-СТА

### **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3<sup>1</sup>-т заасныг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.

### **АУДИТЫН ЗОРИЛТ:**

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн.  
Үүнд:

- Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлыг үндэслэлтэй төлөвлөж хуваарилсан уу?
- Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?

### **АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ:**

Аудитыг орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд, УБЕГ-аас аймгийн УБХ-т хуваарилан, зарцуулсан зардлын төсөв, гүйцэтгэл, тайлагналын баримт материалуудыг хамруулан хэрэгжүүлэв.

### **АУДИТЫН АРГА ЗҮЙ:**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн гаргасан Монгол Улсын Төрийн аудитын стандарт / MNS:6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”-д заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг ашиглан шалгагдагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулж, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага, дүн шинжилгээ

<sup>1</sup> Хуулийн 6.3.Төрийн аудитын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.3.1.шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

хийх, аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлтийг гаргав.

### **АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:**

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- СЕХ-ны 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих, журам”
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоол;
- СЕХ-ны “Ажлын алба”-ны баталсан төсвийн хуваарь;
- Холбогдох бусад хууль эрхийн актууд.

### **АУДИТ ХИЙХ ХУГАЦАА БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:**

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитор Д.Чулуунцэцэг, Б.Наранцэцэг нар 2022 оны 6 дугаар сарын 25-аас 7 дугаар сарын 18-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

### **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлан, 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж, мөрдөж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д заасны дагуу Орхонтуул суманд аймгийн ИТХ-ын нөхөн, Алтанбулаг, Жавхлант, Хушаат, Цагааннуур, Сайхан, Хүдэр сумдад сумын ИТХ-ын нөхөн, Мандал суманд дахин сонгуулийг 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдөр явуулах шийдвэрийг СЕХ-ноос гаргасан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтын дагуу аймгийн ИТХ-ын 2022 оны 03-р сарын 03-ны өдрийн 28 дугаар тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хороонд 9 /баталсан 7 ажилтан болон аймгийн сонгуулийн хорооны захирамжаар ажиллуулсан нягтлан бодогч, нярав/, сумдын салбар хороонд 40, хэсгийн хороонд 102, мэдээллийн технологийн 23 даамал, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан 15, цагдаагийн 12, тагнуулын байгууллагын 2 албан хаагч зэрэг нийт 203 төрийн албан хаагч ажилласан байна.

Сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалт болон хүн амын нягтаршил, газар зүйн байршлыг харгалзан салбар 12 хэсгийн хороог зохион байгуулжээ.

СЕХ-ноос аймгийн Сонгуулийн хороонд 137,796.0 мянган төгрөгийн төсөв хуваарилан, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх, санал авах техник хэрэгслийг тээвэрлэх болон түүнтэй холбогдсон албан хаагчийн сургалт зохион байгуулах болон мөнгөн урамшуулал, унаа, хоолны зардалд нийт 12,261.5 мянган төгрөгийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас аймгийн УБХ-т хуваарилсан байна.

## БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН УУ?

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуулийн зардлыг холбогдох хууль, эрхийн актын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

### 1.1 Аймгийн Сонгуулийн хороо, УБХ-ийн зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан уу?

СЕХ-оос сонгуулийн зардлын төсвийг үндэслэлтэй тооцон төлөвлөж, хуваарилсан байна.

СЕХ-ны 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 3/51 дүгээр албан бичгээр Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд 24,470.0 мянган төгрөгийн, 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 3/82 дугаар албан бичгээр 113,326.0 мянган төгрөгийн зэрэг нийт 137,796.0 мянган төгрөгийн төсөв, санхүүжилтийг хуваарилсан байна.

### Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан төсөв, санхүүжилт

Хүснэгт 1 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр төрөл	Санхүүжилт		
		04.21	06.07	Нийт
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	150.0		150.0
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	1,500.0		1,500.0
3	МТБ, даамлын сургалтын зардал	200.0		200.0
4	Бичиг хэргийн зардал	2,700.0		2,700.0
5	Шуудан, холбооны зардал	3,600.0		3,600.0
6	Унааны зардал	12,320.0		12,320.0
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	3,600.0		3,600.0
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал		12,548.0	12,548.0
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал		390.0	390.0
10	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/		960.0	960.0
11	Сурталчилгааны зардал		5,000.0	5,000.0
12	Томилолтын зардал		4,868.0	4,868.0
13	Унааны зардал /Туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/		840.0	840.0

14	Болзошгүй зардал			
15	Хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал		71,910.0	71,910.0
16	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал		10,810.0	10,810.0
17	Үнэмлэх хэвлүүлэх зардал	400.0		400.0
<b>Нийт дүн</b>		<b>24,470.0</b>	<b>113,326.0</b>	<b>137,796.0</b>

УБЕГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/368 дугаар тушаалаар аймгийн УБХ-т 12,261.5 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.

### Аймгийн УБХ-т хуваарилагдсан төсөв, санхүүжилт

*Хүснэгт 2 /мянган төгрөгөөр/*

№	Зардлын төрөл	Мөнгөн урамшуулал	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардал	Сургалт зохион байгуулах зардал	Техник хэрэгсэл тээвэрлэх болон шуурхай багийн зардал	Нийт зардлын дүн
1	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	7,104.4				7,104.4
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх		1,156.1			1,156.1
3	Сонгогчдын нэрийн жагсаалт хүргэх		860.0			860.0
4	Сургалт томилолт			1,025.0		1,025.0
5	Техник хэрэгслийг тээвэрлэх				2,116.0	2,116.0
<b>Нийт</b>		<b>7,104.0</b>	<b>2,016.1</b>	<b>1,025.0</b>	<b>2,116.0</b>	<b>12,261.5</b>

### 1.2 Сумдын Сонгуулийн хороодын зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан уу?

*Сумдын Сонгуулийн хороодын зардлын төсвийг бодит тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөж, хуваарилсан байна.*

СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам” болон СЕХ-ны 2022 оны 3/51, 3/82 дугаар албан бичгүүдийн хавсралтаар ирүүлсэн төсвийн хуваарийг баримтлан аймгийн Сонгуулийн хорооноос сумдын Сонгуулийн хороодод 109,972.0 мянган төгрөгийн төсвийг хуваарилсан байна. Сумдын Сонгуулийн хороодод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

**Сумдын Сонгуулийн хороонд хуваарилагдсан төсөв, санхүүжилт**

Хүснэгт 3 /мянган төгрөгөөр/

№	Сумдын нэр	Бичиг хэргийн зардал	Шуудан холбооны зардал	Унааны зардал	Санал авах байр, төрийн далбаа бэлтгэх зардал	Сурталчилгаа	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх, Сонгуулийн дүн хүргэх зардал	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	МТ Даамлын сургалтын зардал	Болзошгүй зардал	Урамшуулал, хоол	НИЙТ САНХҮҮЖИЛТ
1	Алтанбулаг	300.0	300.0	800.0	250.0	200.0	1,240.0	80.0	20.0	100.0	7,520.0	<b>10,810.0</b>
2	Мандал	400.0	450.0	1,300.0	500.0	300.0	2,016.0	160.0	30.0	150.0	12,220.0	<b>17,526.0</b>
3	Цагааннуур	400.0	450.0	1,300.0	500.0	300.0	1,380.0	160.0	30.0	150.0	12,220.0	<b>16,890.0</b>
4	Сайхан	300.0	300.0	800.0	250.0	200.0	1,480.0	80.0	20.0	100.0	6,580.0	<b>10,110.0</b>
5	Орхонтуул	500.0	600.0	1,800.0	750.0	400.0	2,216.0	240.0	40.0	200.0	15,040.0	<b>21,786.0</b>
6	Хүдэр	300.0	300.0	800.0	250.0	200.0	1,460.0	80.0	20.0	100.0	7,520.0	<b>11,030.0</b>
7	Жавхлант	300.0	300.0	800.0	250.0	200.0	1,300.0	80.0	20.0	100.0	7,520.0	<b>10,870.0</b>
8	Хушаат	300.0	300.0	800.0	250.0	200.0	1,380.0	80.0	20.0	100.0	7,520.0	<b>10,950.0</b>
	<b>ДҮН</b>	<b>2,800.0</b>	<b>3,000.0</b>	<b>8,400.0</b>	<b>3,000.0</b>	<b>2,000.0</b>	<b>12,472.0</b>	<b>960.0</b>	<b>200.0</b>	<b>1,000.0</b>	<b>76,140.0</b>	<b>109,972.0</b>

Сонгуулийн зардлын төсвийг үндэслэлтэй тооцон хуваарилсан тул төсөвт зохицуулалт хийгдээгүй байна.

**БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?**

*Хуваарилсан төсвийг 7.0 хувиар хэмнэж, хэмнэлтийг татан төвлөрүүлсэн байна.*

**2.1 Аймаг, сумын Сонгуулийн хороод төсөв, санхүүжилтийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?**

*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн хэмнэлт 9,694.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.*

СЕХ-ноос Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хорооны төсвийг нийт 137,796.0 мянган төгрөгөөр баталж, хуваарилснаас 128,101.8 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлт болох 9,694.2 мянган төгрөгийг СЕХ-ны 100900022001 дугаар дансанд татан төвлөрүүлсэн байна.

## Аймаг, сумдын Сонгуулийн хороодын төсвийн гүйцэтгэл

Хүснэгт 4 /мянган төгрөгөөр/

№	Сонгуулийн хороо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт
				/ - /
1	Аймаг	27,824.0	18,159.8	/9,664.2/
2	Алтанбулаг	21,561.0	21,561.0	
3	Мандал	21,611.0	21,581.0	/30.0/
4	Цагааннуур	14,756.0	14,756.0	
5	Сайхан	92,805.0	92,805.0	
6	Орхонтуул	15,796.0	15,796.0	
7	Хүдэр	9,901.0	9,901.0	
8	Жавхлант	21,701.0	21,701.0	
9	Хушаат	21,671.0	21,671.0	
<b>Нийт дүн</b>		<b>137,796.0</b>	<b>128,101.8</b>	<b>/9,694.2/</b>

Аймаг, сумдын Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардал 9,694.2 мянган төгрөгөөр хэмнэгдэхэд дараах зардлууд голлон нөлөөсөн байна.

- **Сурталчилгаа, урамшуулал, болзошгүй зардал:**  
СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ыг баримтлан ажилласнаар сурталчилгааны зардлыг 200.0 мянган төгрөгөөр, урамшуулал хоолны зардлыг 940.0 мянган төгрөгөөр, болзошгүй зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.
- **Унааны зардал:**  
Өмнөх сонгуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажилласнаар унааны зардал 950.0 мянган төгрөгөөр, мэдээ дамжуулах унааны зардлыг 190.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн багийн унааны зардлыг 10.0 мянган төгрөгөөр зэрэг нийт 1,150.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.
- **Сургалт болон томилолтын зардал:**  
СЕХ-оос сургалтыг суманд нь очиж зохион байгуулснаар сургалтын зардал 1,500.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 190.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Харин аймаг, сумын Сонгуулийн хороод нь холбогдох үзүүлэлтүүдээр баталгаажсан цахим баримтаар бус, цахим системд шивэгдээгүй 844.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах....", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг

хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг зөрчсөн тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж байх зөвлөмжийг хүргүүлэв.

## 2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу?

Зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтад үндэслэн бодитоор тайлагнасан байна.

Аймаг, сумдын Сонгуулийн хороод нь сонгуулийн зардлын гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв тайлагнасан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны нэгтгэж, тайлагнасан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар харуулбал:

### Сонгуулийн зардлын гүйцэтгэл

Хүснэгт 5 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр төрөл	Нийт		Хэмнэлт / - /, хэтрэлт / + /
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	150.0	144.8	/5.2/
2	Үнэмлэх хэвлэх зардал	400.0	400.0	
3	Бичиг хэргийн зардал	2,700.0	2,700.0	
4	Шуудан, холбооны зардал	3,600.0	3,600.0	
5	Унааны зардал	12,320.0	11,370.0	/950.0/
6	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	1,500.0	0	/1,500.0/
7	МТБ, Даамлын сургалтын зардал	200.0	170.0	/30.0/
8	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	390.0	380.0	/10.0/
9	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	3,600.0	3,000.0	/600.0/
10	Сурталчилгааны зардал	5,000.0	4,800.0	/200.0/
11	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	12,548.0	12,472.0	/76.0/
12	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх/	960.0	960.0	
13	Томилолтын зардал	4,868.0	4,675.0	/193.0/
14	Мэдээ дамжуулах унааны зардал	840.0	650.0	/190.0/
15	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	71,910.0	70,970.0	/940.0/
16	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	10,810.0	10,810.0	
17	Болзошгүй зардал	6,000.0	1,000.0	/5,000.0/
<b>Нийт дүн</b>		<b>137,796.0</b>	<b>137,796.0</b>	<b>/9,694.2/</b>

УБЕГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/368 дугаар тушаалаар аймгийн УБХ-т 12,261.5 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсныг тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн 100130012420 дугаар дансанд төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

## УБХ-т олгосон санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 6 /мянган төгрөгөөр/

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт / - /, хэтрэлт / + /
1	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	7,104.4	7,104.4	
2	Сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх бичиг хэргийн зардал	1,156.1	57.0	/1,099.1/
3	Сонгогчдын нэрсийн жагсаалт хүргэх	860.0	860.0	
4	Сургалтын зардал	1,025.0	1,025.0	
5	Техник хэрэгсэл тээвэрлэх болон шуурхай багийн зардал	3,899.0	3,899.0	
	<b>Нийт</b>	<b>12,261.5</b>	<b>11,162.4</b>	<b>/1,099.1/</b>

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сонгогчийн нэрийн жагсаалт хэвлэх зардлаас хэмнэгдсэн 1,099.1 мянган төгрөгийг УБЕГ-ын нэмэлт санхүүжилтийн 100900012419 дүгээр дансанд төвлөрүүлсэн байна.

### 2.3 Хөрөнгийн зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт хийсэн үү?

*Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн зардлын гүйцэтгэлийг хянаж, холбогдох зөвлөмж, чиглэлийг өгсөн байна.*

СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.10-т “Сонгуулийн Ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн Сонгуулийн хороо нь сум, дүүргийн Сонгуулийн хорооны, ... зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь СЕХ-ноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу 137,796.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймаг, сумдын Сонгуулийн хороодод хуваарилан, арвилан хэмнэлттэй зарцуулах, бүртгэлийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, тайлагнах, зарцуулалтын байдалд хяналт тавих тухай болон 2020 оны УИХ, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн талаар цахим сургалт зохион байгуулж, үүрэг, чиглэл өгсөн байна.

Аймгийн Сонгуулийн хорооноос сумдад хуваарилсан зардлын гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор сумдын Сонгуулийн хороодын санхүүгийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа ажилтны судалгааг гаргаж, фейсбүүк групп, мэйл хаягаар мэдээ, мэдээлэл, чиглэл өгч, төсвийн зарцуулалт, эсэх, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн, арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

Аймаг сумдын Сонгуулийн хороод нь өмнөх аудитуудаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласнаар зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, шатахууны жишиг нормыг мөрдөөгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан зэрэг зөрчлүүдийг давтан гаргаагүй байна.

## ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар аймаг, сумын Сонгуулийн хороод нь холбогдох үзүүлэлтүүдээр баталгаажсан цахим баримтын бүрдэлгүй, цахим системд шивэгдээгүй 844.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн зөрчил илэрч, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

## ДҮГНЭЛТ

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуулийн зардлыг холбогдох хууль, эрхийн актын дагуу хуваарилсан байна.
- Аймаг, сумдын Сонгуулийн хороод нь хуваарилсан төсөв, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Аймгийн дүнгээр сонгуулийн зардлын төсвийг 7,0 хувиар буюу 9,694.2 мянган төгрөгөөр хэмнэж, үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.
- УБХ нь хуваарилагдсан төсвийг 1,099.1 мянган төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг татан төвлөрүүлсэн байна.
- Аймаг, сумдын Сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв тайлагнасан байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, шатахууны жишиг нормыг мөрдөөгүй зэрэг зөрчлүүдийг давтан гаргаагүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

**Аймаг, сумдын Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нарт:**

- Бараа материалын худалдан авалтын ажил гүйлгээг төлбөрийн цахим баримтыг үндэслэн гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА  
Б.БАТМӨНХ  
Д.ЧУЛУУНЦЭЦЭГ  
Б.НАРАНЦЭЦЭГ

**Аймгийн Сонгуулийн хорооны санал, тайлбар**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРОО**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг  
Утас/Факс: 7036-3966

*2022.07.07* № *20*

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуулийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийсэн дүгнэлтийн төсөлтэй танилцлаа.

Дүгнэлтийн төсөлтэй холбоотой санал байхгүй болно.

ДАРГА *[Signature]* Ө.СУВДАА

